



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

СОЁМБОМ ЭДЭЭ

№212 /421/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.11.25

Цаг үе, үйл явдал

ШИНЭ ДАЙЧИД МУЗЕЙГЭЭР...



Зэвсэгт хүчний 015 дугаар анги

Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн хурандаа О.Сэрдариин нэрэмжит Цэргийн гавьяаны улаан тугийн одонт, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн шинэхэн дайчид Монголын Уран зургийн галерейн "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т оролцлоо. Тус өдөрлөгийн хүрээнд бие бүрэлдэхүүн "Галерейн тайлбартай аялал", "Хөгжимтэй зураг", "Урлагийн сэтгэл засал", "Эрчист Монгол өргөө" зэрэг арга хэмжээнд хамрагдсан юм.

Ахлах дэслэгч Д.ДАВААЖАРГАЛ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-16	-24

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,426	3,432
EUR	3,550	3,570
CNY	478	481
RUB	53.80	54
JPY	24.40	24.70
KRW	2.53	2.57

ШИНЭ ДАЙЧДЫН ЦАНГИНАСАН ДУУ, БҮЖГЭЭР ДОРГИЛОО



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

2022 оны II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан ирсэн шинэ дайчдын бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэх зорилгоор "Тэргүүний шилдэг салаа" шалгаруулах цогцолбор тэмцээнийг зохион байгуулж байна.

Үүний нэг төрөл болох "Урлагийн үзлэг"-ийн аварга шалгаруулах тэмцээн багийн мэндчилгээ, хамтлаг дуу, гоцлол дуу, хамтлаг бүжиг, гоцлол бүжиг, язгуур урлаг, уран уншлага, гоц үзүүлбэр, гоцлол хөгжим гэсэн 9 төрлөөр амжилттай зохион байгуулагдлаа.

Тэмцээний шүүгчээр Захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга хошууч Д.Мөнхбаатар, соёлын төвийн арга, МУСТА, ахмад Б.Норов-Эрдэнэ, Үлээвэр найрал хөгжмийн удирдаач ахмад Б.Мөнхбат нар ажилласан юм.

Тэмцээний нэгдсэн дүнгээр тэргүүн байрт дэслэгч Х.Тэмүүжин захирагчтай ХХТР-ын I салаа, дэд байрт дэслэгч Х.Дамдиндорж захирагчтай ХҮТР-ын II салаа, гутгаар байрт дэслэгч О.Пүрэвбат захирагчтай ХҮТР-ын III салаа тус тус шалгарав.

Ахмад Т.ДЭЛГЭРМАА



ЗУРХАЙ

2022.11.25 /БААСАН ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 22

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН
ГАХАЙ САР
ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ
ХАР МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал:
Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.12-17.06
Барилдлага:
Шид
Шүтэн барилдлага:
Өтлөх үхэхүй

ШИНЭХЭН ДАЙЧИД БУУДЛАГА ХИЙЛЭЭ



Зэвсэгт хүчний 110 дугаар анги

2022 онд хугацаат цэргийн албанд татагдсан дайчид цэргийн анхан шатны бэлтгэл, сургалтдаа хуваарийн дагуу хамрагдаж байна.

Тухайлбал дайчид энэ сарын 23-ны өдөр тангаргийн буудлага амжилттай төлөвлөн явуулсан бөгөөд энэ үеэр нийт 11 байлдагч онц буудаж бусад нөхдөө манлайлсан юм.

Буудлага эхлэхийн өмнө бие бүрэлдэхүүнд ангийн захирагчийн тушаал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулан аюулгүй байдал, сахилга, дэг журмыг чанд сахих тухай үүрэг чиглэлийг өгч ажиллалаа.

Ахмад Т.МӨНХ-ЭРДЭНЭ



ИХ ЭЗЭН БОГД ЧИНГИС ХААНЫ ЭШ ХӨРГИЙГ ХҮНДЭТГЭН ЗАЛЛАА



Монгол бахархлын өдрийг тохиолдуулан Их Эзэн Богд Чингис хааны суу алдар, түүхэн үйл хэргийг сурвалжлан судлах, түгээн дэлгэрүүлэх, эрхэмлэн дээдлэх, алдаршуулан мөнхжүүлэх, төрт ёсны үнэн зөвийг бэхжүүлэх, эв эеийг бататгах үүднээс Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүн Чингис хааны эш хөргийг хүндэтгэн заллаа.

Б.ПАГАМДУЛАМ



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 644,781,932

Эдгэрсэн

Нийт: 623,600,306

Нас барсан

Нийт: 6,632,355

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 353 дугаар анги

Зэвсэгт хүчний агаарын цэргийн командлалын Агаарын довтолгооноос хамгаалах хэлтсээс “Пуужингийн харвалттай тактикийн хээрийн сургуулийн туршлага, сургамж” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.

Хуралд Агаарын цэргийн штабын дарга бригадын генерал Б.Эрдэнэбат, ЗХЖШ-ын БСТГ-ын дарга бригадын генерал Ц.Гандорж, бэлтгэл хошууч генерал О.Энхбаяр, ҮБХИС-ийн Агаарын цэргийн тэнхимийн дарга хурандаа Б.Ганзам, эрдэмтэн багш нар, сонсогчид, энх тэнгэрийн харуул ТББ-ын гишүүд, Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн зенит пуужин, радио техникийн мэргэжлийн офицерууд оролцлоо. Уг эрдэм шинжилгээний хуралд Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн захирагч хурандаа Ш.Аюурзана “Зенит пуужингийн анги, салбаруудын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага”, ҮБХИС-ийн БХУА-ын Оператив тактикийн төвийн ахлах багш доктор (Ph.D) хурандаа Т.Энхбат “Гадаадын армиудын зенитийн пуужингийн цэргийн зэвсэглэл, техникийн хөгжил”, АЦК-ын

зенитийн пуужингийн ахлах офицер-ерөнхий инженер хошууч Ц.Отгонбаяр”, “Сүүлийн үеийн дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөнд зенитийн пуужингийн цэргийг ашиглаж байгаа туршлага сургамж”, АЦК-ын сургалтын офицер дэд хурандаа О.Амарсанаа “Зенитийн пуужингийн сургалт бэлтгэлийн өнөөгийн байдал, чиг хандлага”, Бэлтгэл хурандаа Х.Чойжамц, хурандаа А.Мөнхбат нар УАДХЦ-ийн Командлалын “Пуужингийн харвалттай тактикийн хээрийн сургууль явуулах, төлөвлөлт зохион байгуулалт”, Бэлтгэл хурандаа Х.Зориг, дэд хурандаа Я.Хундаганай нар “Пуужингийн харвалттай тактикийн хээрийн сургуулийн туршлага сургамж” Бэлтгэл хурандаа А.Мөнхбат, хурандаа Г.Галбадрах нар “Пуужингийн харвалттай тактикийн хээрийн сургуульд бие бүрэлдэхүүний бэлтгэл, туршлага сургамж”, АЦК-ийн хүний нөөцийн хэлтсийн дарга хурандаа Д.Түмэндэлгэр “Зенитийн пуужингийн мэргэжилтэн бэлтгэх бодлого, өнөөгийн байдал” сэдвээр тус тус илтгэлээ танилцууллаа.

Ахмад Б.ГАНЧУЛУУН

МОРЬТОН ДАЙЧИД БУУДЛАГЫН АНХНЫ ДАСГАЛ БОЛОВСРУУЛАВ



Зэвсэгт хүчний 232 “Духан” районд автоматын дугаар ангид 2022 оны хоёрдугаар ээлжийн цэргийн албанд татагдан ирсэн дайчид шинэ сургуулийн жилийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу


үйеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулсны зэрэгцээ буудлагын болон хөдөлгөөний үед нэн тэргүүнд аюулгүй байдлыг ханган ажилласан юм.

Энэхүү сургалтаар хугацаат цэргийн алба хаагчид анхан шатны бэлтгэл, сургалтын үед танхимаар олсон онолын мэдлэгээ газар орон дээр бататгасны зэрэгцээ тэдний сэтгэл зүйн болон бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлсэн чухал ач холбогдол бүхий сургалт болсон юм.

Ийнхүү хугацаат цэргийн албанд шинээр татагдан ирсэн дайчдад цэргийн мэргэжил олгох шатны сургалтыг амжилттай зохион байгуулсаар байна. Онц мэргэн буудсанд сургалтын төвийн дарга нар нь сэтгэгдэл дүүрэн, дайчин цэргүүд урам зориг дүүрэн цэргийн тангаргаа өргөхөд бэлэн боллоо.

Ахмад С.ОЧИРБАТ

БУУ НЬ ЦЭЦЭН, БАЙЛДАГЧ НАР НЬ МЭРГЭН БАЙЛАА



БНМАУ-ын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит, Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 167 дугаар ангид 2022 оны 2 дугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчдад цэргийн мэргэжил олгох сургалт амжилттай явагдаж байна. Дайчдыг галын бэлтгэл хичээлийн хөтөлбөрийн

дагуу онол болон дадлагаар сурган мэргэшүүлсний дараагаар цэргийн мэргэжил олгох шатны төгсгөлийн буудлагыг энэ сарын 22-ны өдөр зохион явуулахад нийт 22 байлдагч цэцэн бугаа туузаар чимж онц буудагч болж бахдам амжилтын эзэд болцгоолоо.

Дэслэгч Б.БАТЗАЯА

СУРГАЛТ

СУРГАЛТ БЭЛТГЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ЯВАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 084 дүгээр анги

Ангийн 2022-2023 оны сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу хүн нэг бүрийн буудлагыг Хужир булан дахь ТХСТ-ын буудлагын полигонд зохион байгууллаа.

Мөн энэ үеэр бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх дадлага, ур, чадварыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр



тэвчээрийг дээшлүүлэх рот, салааны захирагч, бүлгийн дарга нарын удирдах арга барилыг нэмэгдүүлэх зорилгоор 20км явган маршийг Цагдуулт Уул, Улиастайн гол, Цагдаа даваа, ангийн байрлал гэсэн маршрутаар цаг агаарын хүндрүүлсэн нөхцөлд зохион байгуулж явуулав.

Хошууч Б.Дэрдэнэнинж

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №26

ЛА ГИЙГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ

ЛА бол зөөлөн дэвсгэр үсэг юм. Үгийн дунд, төгсгөлд ардаа эгшиггүй тохиолдож болно.

ЛА үсгийн үндсэн бүтэц бол НА, МА-гийн адил титэм бөгөөд ялгах зурлага “эвэр” нэмж бичдэг. Үгийн дунд, адагт дэвсгэрлэвэл “шүд, эвэр”-ээр тэмдэглэнэ. Эхлээд нурууны шугам дээр титэм зэрэг үсэг зурлагаа бичиж дуусаад, үзгээ салган эврийг титэм, шүдэнд нь зайгүй нийлүүлж бичдэг. Үгийн төгсгөлд, шүднээс залгуулан нар буруу эргүүлсхийн эврийг гаргадаг. ЛА-гийн эврийг хөндий бичиж болохгүй. Та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд орох ЛА, ЛЭ, ЛИ, ЛО, ЛУ, ЛӨ, ЛҮ гэж аялгуулан уншиж, хувирах хэлбэрийг тогтоогтун.

Бичмэл тигээр:

